

Элементүүдийн абсолют утгуудын нийлбэр

Бүхэл тоон элементүүдээс тогтох массив өгөгдсөн бөгөөд чи дараах үйлдлүүдийг гүйцэтгэх X бүхэл тооноос тогтсон

q ширхэг асуулгуудад хариулах ёстой.

- Уг X тоог массивын элемент бүр дээр нэмж, дараагийн асуулгуудад бэлдэж массивыг шинэчлэх
- Массивын элемент бүрийн абсолют (Модуль) утгыг олж, тэдгээрийн нийлбэрийг шинэ мөрөнд хэвлэх

Санамж: Бодлогын оролт гаралтын хэмжээ маш том учраас асуулга бүрт хариулж амжих зөв шийдлийг олох шаардлагатай болно.

Оролтын хэлбэр

Эхний мөрөнд массивын элементийн тоог илэрхийлэх n тоо өгөгдөнө.

Хоёрдугаар мөрөнд n ширхэг массивын элементүүд зайгаар тусгаарлагдан өгөгдөнө.

Гуравдугаар мөрөнд асуулгын тоо болох q тоо өгөгдөнө.

Дөрөвдүгээр мөрөнд хоорондоо зайгаар тусгаарлагдсан q ширхэг асуулгыг илэрхийлэх X тоонууд өгөгдөнө.

Хязгаарлалт

$$1 \leq n \leq 5 \cdot 10^5$$

$$1 \leq q \leq 5 \cdot 10^5$$

$$-2000 \leq \text{Arr}[i] \leq 2000 \quad \text{Энд } 0 \leq i < n$$

$$-2000 \leq \text{queries}[j] \leq 2000 \quad \text{Энд } 0 \leq j < q$$

Гаралтын хэлбэр

Асуулга бүрийн хувьд массивын бүх элементүүдийн абсолют утгуудын нийлбэрийг шинэ мөрөнд хэвлэнэ.

Жишээ оролт

3

-1 2 -3

3

1 -2 3

Жишээ гаралт

5

7

6

Тайлбар

Асуулга 0: X=1

Массив: [-1, 2, -3] -> [0, 3, -2] болно.

Массив : [0, 3, -2] -> [-2, 1, -4]

Шинэчлэгдсэн массивын абсолют утгуудын нийлбэрийг олбол: $|0|+|3|+|-2|=0+3+2=5$

Асуулга 1: X=-2

Шинэчлэгдсэн массивын абсолют утгуудын нийлбэрийг олбол: $|-2|+|1|+|-4|=2+1+4=7$

Асуулга 2: X=3

Массив : [-2, 1, -4] -> [1, 4, -1]

Шинэчлэгдсэн массивын абсолют утгуудын нийлбэрийг олбол: $|1|+|4|+|-1|=1+4+1=6$

Орчуулсан : Хөвсгөл аймгийн Ирээдүй сургуулийн багш Д.Батмөнх